

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ – ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

(2022 оны жилийн эцсийн байдлаар тайлагнав)

2022-12-23

Улаанбаатар хот

Д/ д	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн, Хэрэгжилтийн хувь
Зорилт 1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх						
1	1.1. АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (facebook, twitter, youtube), лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэх.	Жилдээ, тухай бүр	Олон хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байдал; Баримтжуулсан байдал; Үр дүнг тайлагнасан байдал.	Олон нийтэд түгээн сурталчилж, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна; Баримт нотолгоонд үндэслэн үр дүнг тайлагнасан байна.	Батлагдсан төсвийн урсгал зардал	<p>Авлигатай тэмцэх газраас олон нийтийн хүртээл болгож, авлига, ашиг сонирхлын зөрчлийн хор холбогдол, хууль тогтоомжийг таниулах, сурталчлахаар ирүүлсэн ТВ шторк, зурагт хуудас, теле зохиомж, гарын авлага зэргийг байгууллагын албан ёсны цахим хуудас https://pcsp.gov.mn, нийгмийн сүлжээний фэйсбүүк пейж https://www.facebook.com/pcsp.gov.mn хуудсандаа нийтлэх, мэдээллийн самбарт байршуулах зэргээр олон нийтийн хүртээл болгож байна. Тайлант онд шинээр хүлээн авсан нийт 19 төрлийн шторк, зурагт хуудсыг олон нийтэд ээлж дараатайгаар сурталчлан таниулах төлөвлөлт, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллав. Энэ хүрээнд байгууллагын цахим хуудасны “Авлигын эсрэг үйл ажиллагаа” цэсийн “Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” https://pcsp.gov.mn/?page_id=5660# хэсэгт байршуулсан болно.</p> <p>Мөн Авлигатай тэмцэх газраас 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 01/3817 дугаартай албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу олон нийтийн сүлжээн дэх “Авлигатай тэмцэх газар” болон “АТГ - Олон нийтийн төв” фэйсбүүк пейж хуудсыг албан хаагчдын дунд сурталчлан танилцуулж, албан хаагчдыг тус хуудсанд нэгдэх, дагахыг уриалан, Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж байгаа “Зөв зөвд шударга зөв” аянд нэгдэх арга хэмжээ авсан.</p> <p>Авлигатай тэмцэх газраас хүлээн авсан гарын авлага, авлигын</p>

						<p>хор холбогдлыг сурталчилсан зурагт хуудас, 110 дугаартай утасны сурталчилгааны зурагт хуудас, хууль тогтоомжийн товхимол зэргийг 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр ТӨБЗГ-т зохион байгуулагдсан мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудын (салбар ЭБАТ-ууд) сургалтын үеэр тараасан.</p> <p>Хэрэгжилт – 100 хувь.</p>
2	1.2. АТГ-аас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах.	Жилдээ	Байгууллагын хэмжээнд зохион байгуулсан ажлын үр дүнг тайлагнасан байдал.	Дэмжиж, хамтран ажилласан байна; Зохион байгуулсан ажил, үр дүнг тайлагнасан байна.	Батлагдсан төсвийн урсгал зардал	<p>Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж байгаа “Зөв зөвд шударга зөв” аянд байгууллагын нийт албан хаагчдыг нэгтгэх арга хэмжээ авч, авлигатай тэмцэхэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд албан хаагчдын идэвх, оролцоог хангаж, байгууллагын зүгээс авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх чиглэлээр ажилласан байна. Энэ хүрээнд нийгмийн сүлжээн дэх “Авлигатай тэмцэх газар” болон “АТГ-Олон нийтийн төв” фэйсбүүк пейж хуудсыг албан хаагчид дагаж, олон нийтэд мэдээлэл хүргэх, авлигатай тэмцэхэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх ажилд дэмжлэг үзүүлэхэд анхаарч байна. Тухайлбал, Авлигатай тэмцэх газраас гаргасан ном товхимол, зурагт хуудас, шторкийг байнга сурталчлан түгээх, байгууллагын албан ёсны цахим хуудас https://pcsp.gov.mn болон фэйсбүүк пейж https://www.facebook.com/pcsp.gov.mn хуудсанд нийтлэх зэргээр олон нийтийг соён гэгээрүүлэх, мэдээлэл түгээх арга хэмжээнд нэгдэн ажиллаж байна.</p> <p>Хэрэгжилт – 100 хувь.</p>
3	1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах.	Жилдээ, тухай бүр	Мэдээллийн олон талт байдлыг хангаж, түгээн сурталчлах.	Мэдээллийг тогтмол шинэчлэх ажлыг хэвшүүлэх; Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн мэдээллийг байршуулсан байх.	Батлагдсан төсвийн урсгал зардал	<p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын байрлаж байгаа Засгийн газрын 9 дүгээр байранд байршин үйл ажиллагаа явуулж байгаа Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Төрийн худалдан авах ажиллагааны газар, Жижиг, дунд үйлдвэрийн газар, Мал эмнэлгийн ерөнхий газар гэсэн 3 байгууллага тус бүрд “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарыг тус тус ажиллуулж, олон нийтийг мэдээллээр хангаж байгаа болно. Авлигатай тэмцэх газраас бэлтгэн байгууллагуудад байршуулан ажиллуулж байгаа уг самбарыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт</p>

					<p>тусгайлан олгоогүй болно. (Тус байршилд 3 самбар байгаа нь хангалттай гэж АТГ-ын холбогдох албан тушаалтнаас тухайн самбарыг байгууллагуудад хүлээлгэж өгч байх үед хариу авч байсан болно.)</p> <p>Авлигатай тэмцэх газраас хэвлүүлэн тараасан “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” зурагт хуудсыг байгууллагын нэгж хэсгүүдэд байршуулан сурталчилж байна. Мөн харьяа төрийн өмчит хуулийн этгээдийн мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудад 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт зохион байгуулсан сургалтын үйл ажиллагааны үеэр тарааж, тухайн байгууллагадаа сурталчлан таниулах талаар чиглэл өгсөн болно.</p> <p>Мөн “Авлигыг мэдээлэх утас 110” цахим постерыг байгууллагын цахим хуудас, болон нийгмийн сүлжээн дэх фэйсбүүк пэйж хуудсандаа байршуулан олон нийтэд сурталчилж байна.</p> <p>Хэрэгжилт – 100 хувь.</p>
--	--	--	--	--	--

Зорилт 2. Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг сургалтад хамруулах

4	2.1. Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгуулахаар АТГ-т хүргүүлж, албан хаагчдаа холбогдох сургалтад хамруулсан байх.	1-2 сард	Сургалтын хэрэгцээг тодорхойлж, Авлигатай тэмцэх газарт захиалга хүргүүлсэн байх; Авлигатай тэмцэх газрын сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо.	Сургалтын хэрэгцээг тодорхойлж, захиалгыг Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн байна; Авлигатай тэмцэх газрын сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо – 25<.	Батлагдсан төсвийн урсгал зардал	<p>Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөөнд сургалт, соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн тусгаж, хэрэгжилтийг хангаж байна.</p> <p>Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах хэрэгцээ шаардлагыг судлан Авлигатай тэмцэх газрын УССГХ-т сургалт авах санал захиалгыг өгч, сургалтын төлөвлөгөөнд тусгуулах арга хэмжээ авсан.</p> <p>АТГ-тай хамтран зохион байгуулсан дараах сургалтуудад нийт 170 албан хаагчийг хамруулсан байна:</p> <ul style="list-style-type: none"> – Анхан шатны сургалт, 2022.02.23, цахимаар – 40 албан хаагч (ТӨХЭТгээд); – Давтан сургалт, 2022.02.24, цахимаар – 20 албан хаагч (ТӨБЗГ); – Давтан сургалт, 2022.03.04, цахимаар – 20 албан хаагч
---	---	----------	---	---	----------------------------------	---

						<p>(ТӨХЭТгээд);</p> <p>–“Төрийн байгууллагын удирдах албан тушаалтны ёс зүй, манлайллыг дээшлүүлэх, авлигын шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах, таслан зогсоох нь” авлигын эсрэг даvtан сургалт, 2022.03.30, АТГ-ын “Олон нийтийн төв”-ийн танхимд – 30 (ТӨХЭТгээдийн удирдах ажилтан, УБ-д байршилтай.)</p> <p>–Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтны сургалт, 2 удаа, цахимаар – 60 (давхардсан тоогоор).</p> <p>Хэрэгжилт – 100 хувь.</p>
5	2.2. Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан байдал.	Жилдээ, тухай бүрд	Сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд хамрагдалтын хувь.	Хамрагдалт – 100 хувь.	Батлагдсан төсвийн урсгал зардал	<p>Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 06/13971 тоот албан бичгээр ирүүлсэн 01 дугаартай Мөрдөгчийн мэдэгдлийн дагуу “Мөрдөгчийн мэдэгдлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний төлөвлөгөө, “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусгасны дагуу “Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх нь” сургалтыг бэлтгэн 2022.01.21-ний өдөр зохион байгуулж, ТӨБЗГ-ын 31 албан хаагчийг хамруулсан. Мөн энэхүү сургалтын хөтөлбөрийн хүрээнд Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс сургалт захиалан авч, авлигын хор хөнөөл, хууль тогтоомжийн талаар цахим сургалт хийсэн бөгөөд Төрийн албан хаагчийн ёс зүй, ёс суртахууны асуудлаар Удирдлагын академийн багш, профессор А.Алтанзулыг урьж, нийт албан хаагчдад лекц уншуулсан.</p> <p>2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр АТГ-тай хамтран харьяа төрийн өмчит хуулийн этгээдийн ЭБАТ-д зориулсан сургалт зохион байгуулж, тэдгээрийн чадавхыг дээшлүүлэх арга хэмжээ авсан. Нийт ЭБАТ-ын 47.6 хувь (20 ЭБАТ) нь буюу сүүлийн 1 жилийн хугацаанд шинээр томилогдсон ЭБАТ-ууд танхимаар, бусад нь цахимаар хамрагдав. Уг сургалтын үйл ажиллагааны зардалд байгууллагын төсвөөс 220.0 мянган төгрөгийг зарцуулсан болно. Уг сургалтын хөтөлбөрт АТГ-ын УССГХ болон ХШДШХ-ээс холбогдох сэдвийн хүрээнд мэдээлэл, семинар өгсөн. Тус сургалтад ТӨБЗГ-аас “ЭБАТ-ын</p>

					<p>үйл ажиллагаанд анхаарах асуудал” сэдвийн хүрээнд арга зүйн зөвлөгөө, зааварчилгааг дэлгэрэнгүй байдлаар өгч, ажил хэргийн ярилцлага, асуулт – хариултыг өргөн хүрээнд зохион байгуулсан. Сургалтад танхимаар оролцогчдоод авлигын эсрэг үйл ажиллагааг зохион байгуулах асуудалтай холбоотой гарын авлага, ном, товхимол, зурагт хуудсыг олгосон.</p> <p>Мэдүүлэг гаргагч албан хаагчид болон харьяа байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан (ЭБАТ)-ыг тухай бүр зөвлөгөө, арга зүйгээр хангаж ажиллав. Тайлант жилд авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх чиглэлээр ТӨБЗГ-ын мэдүүлэг гаргагч албан хаагчид, харьяа төрийн өмчит хуулийн этгээдийн захирал, мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах ЭБАТ зэрэг нийт 551 албан хаагчид мэдээлэл, зөвлөгөө, арга зүйн дэмжлэг үзүүлэн ажилласан байна. Хамрагдалтыг ангилан танилцуулбал:</p> <ul style="list-style-type: none"> – сургалтад 170 албан хаагч; – мэдээлэл, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгт – 262 албан хаагч; – хуулийн хугацаа сануулах арга хэмжээнд – 119 албан хаагч. <p>Мэдүүлэг гаргагч албан хаагчдад хуулийн хугацаа сануулах ажлыг тухай бүр мэдээлэл, санамж, зөвлөгөө хэлбэрээр өгч ажилласан. Тухайлбал, ТӨБЗГ-т мэдүүлэг бүртгүүлсэн 119 албан хаагчид хуулийн хугацааг сануулж, мэдүүлгийг гаргуулан авсан бөгөөд хуулийн хугацаа хоцроосон тохиолдол гаргаагүй байна.</p> <p>Хэрэгжилт – 100 хувь.</p>
--	--	--	--	--	---

Зорилт 3. Авлигатай тэмцэх газраас гаргасан шийдвэрийг биелүүлэх

6	3.1. Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх.	Жилдээ, тухай бүр	Зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг тайлагнасан байх.	Зөвлөмжийн хэрэгжилт хангагдсан байна.	Батлагдсан төсвийн урсгал зардал	<p>Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн албан бичиг, чиглэл, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж байгаа байдалд хяналт тавьж ажиллав.</p> <p>2022.12.23-ны өдрийн байдлаар ТӨБЗГ-т АТГ-аас нийт 82 албан бичиг ирүүлсэн бүртгэлтэй байгаа бөгөөд тэдгээрээс 37 нь хариутай бичиг байна. Хариутай бичгийн 35 нь</p>
---	--	-------------------	---	--	----------------------------------	--

					<p>шийдвэрлэгдсэн бөгөөд шийдвэрлэлт 94.6 хувьтай байна.</p> <p>Ирсэн бичгийн агуулга:</p> <ol style="list-style-type: none"> 1. Харилцсан бичиг (хүсэлт, хариу хүргүүлэх, материал буцаах, хамтран ажиллах тухай г.м.) – 63; 2. Чиглэл өгсөн – 4; 3. Зөвлөмж – 1; 4. Мөрдөгчийн мэдэгдэл – 3; 5. Хариуцлага тооцуулах тухай – 1; 6. Материал гаргуулах, нотлох баримт гаргуулах тухай – 10. <p>Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ хүрээнд өгсөн чиглэл, зөвлөмж, мөрдөгчийн мэдэгдэлд тухай бүр хариу өгсөн байх бөгөөд 1 зөвлөмжийг 2022.12.06-ны өдөр, 1 чиглэлийг 2022.12.16-ны өдөр тус тус хүлээн авсан, шийдвэрлэж хариу өгөх хугацаа болоогүй байна.</p> <p>АТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 05-ны 01/16426 дугаар зөвлөмжид уул уурхайн салбарын төрийн өмчит үйлдвэрийн газруудын гүйцэтгэх удирдлагын ажлын үр дүн, урамшууллын эрх зүйн орчин, дүрэм журам, аргачлалд өөрчлөлт оруулах асуудлыг хөндсөн бөгөөд цаашид, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай анхдагч хуулийн үзэл баримтлал, Авлигатай тэмцэх газраас өгч буй зөвлөмжийн хүрээнд холбогдох журмыг шинэчлэн боловсруулах асуудлыг судлахаар төлөвлөж байна.</p> <p>АТГ-ын 2022.12.14-ний өдрийн 03/17067 дугаартай албан бичгээр 2023 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийн ажилд бэлтгэх тухай чиглэл өгсний дагуу холбогдох арга хэмжээг ТӨБЗГ-т үе шаттай хэрэгжүүлэн ажиллаж байна. Харьяа төрийн өмчит 46 хуулийн этгээдэд ТӨБЗГ-ын 2022.12.21-ний өдрийн А-1/2531 дугаартай албан бичгээр уг чиглэлийг хүргүүлэв. Эхний хариуг 2023 оны 01 дүгээр сарын 10-ны дотор хүргүүлэхээр бэлтгэл, зохион байгуулалтын арга хэмжээ авав.</p> <p>Хэрэгжилт – 100 хувь.</p>	
7	3.2. Мөрдөгчийн мэдэгдэлд тусгагдсан	Жилдээ, тухай бүр	Хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр	Мэдэгдлийг хэрэгжүүлж,	Батлагдсан төсвийн	<p>Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 06/13971 тоот албан бичгээр</p>

	арга хэмжээг авч хэрэгжүүлэх.		дүнг тайлагнасан байх.	тайлагнасан байна.	урсгал зардал	ирүүлсэн 01 дугаартай Мөрдөгчийн мэдэгдлийг хүлээн авч, мэдэгдэлд тусгасан зөрчил арилгах, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бөгөөд энэ талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А-1/156 дугаартай албан бичгээр хариу мэдээллийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн байна. 2022 онд шинээр хүлээн авсан № 32, 45, 96 дугаартай Мөрдөгчийн мэдэгдлийг шийдвэрлэхээр холбогдох байгууллагад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг тухай бүр авч ажиллан хариуг АТГ-т ТӨБЗГ-ын 2022 оны А-1/710, 777, 1923 дугаартай албан бичгээр хүргүүлсэн байна. Хэрэгжилт – 100 хувь.
8	3.3. Зөрчил арилгуулах албан бичигт тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	Жилдээ, тухай бүр	Зөрчил арилгуулах арга хэмжээ авсан байх.	Зөрчил арилгах талаар авсан арга хэмжээний үр дүнг тайлагнасан байна.	Батлагдсан төсвийн урсгал зардал	Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 06/13971 тоот албан бичгээр ирүүлсэн 01 дугаартай Мөрдөгчийн мэдэгдлийг хүлээн авч, мэдэгдэлд тусгагдсан зөрчил арилгах, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бөгөөд энэ талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А-1/156 дугаартай албан бичгээр хариу мэдээллийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн байна. Авлигатай тэмцэх газрын 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 05/289 дугаартай “Хариуцлага тооцуулах тухай” албан бичигт тусгагдсан холбогдох албан тушаалтан (“Замын-Үүдийн дулааны станц” ТӨҮГ)-д хариуцлага тооцож, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 05 дугаар тогтоол гаргасан. Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга, Эрхэлсэн комиссар Т.Энхболдод 2022 оны А-1/170 дугаартай албан бичгээр тухайн албан хаагчид хариуцлага тооцсон тухай хариу хүргүүлсэн. Хэрэгжилт – 100 хувь.
Зорилт 4. Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх						
9	4.1. Авлигын эсрэг төрийн болон төрийн	Тухай бүр	Санал, санаачилга,	1-2 аян, санал, уриалгад нэгдсэн	Батлагдсан төсвийн	Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар хуулиар хүлээсэн үүргийн дагуу Авлигатай тэмцэх үндэсний

<p>бус байгууллага, хувийн хэвшил, иргэдээс гаргасан санал, санаачилгыг дэмжин туслах.</p>		<p>уриалга, аянд нэгдсэн байдал; Бусад байгууллагатай хамтран ажилласан байх.</p>	<p>байна; Хамтран ажилласан байгууллагын тоо – 2<.</p>	<p>урсгал зардал</p>	<p>хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж, байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, хэрэгжилтийн тайланг тогтоосон хугацаа, хуваарийн дагуу АТГ-т тайлагнан мэдээлж, тэдгээрийн нээлттэй байдлыг ханган ажилласан байна.</p> <p>Ерөнхий сайдын 2021 оны 120 дугаар захирамжаар байгуулагдсан “Авлигын индексийг бууруулах зорилго бүхий Ажлын хэсэг”-ийн авч хэрэгжүүлэх эрчимжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөөний 4 бүлгийн хүрээнд тусгагдсан холбогдох 10 арга хэмжээг хэрэгжүүлж, биелэлтийг тайлагнав. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн үйл ажиллагаа болон төрийн захиргааны байгууллагын нийтлэг үүрэгтэй холбоотой тусгагдсан эдгээр 10 арга хэмжээний хэрэгжилтийг 2022 оны эхний хагас жилийн байдлаар 97.0 хувийн гүйцэтгэлтэй буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” үнэлгээтэйгээр тайлагнасан.</p> <p>Авлигатай тэмцэх газрын 110 дугаартай утсыг сурталчлах, “Зөв зөвд шударга зөв” аянд нэгдэж, Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангахад дэмжлэг үзүүлэх, байгууллагын үйл ажиллагааг ил тод мэдээлэх, сул орон тоог нөхөх үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу нээлттэй, сонгон шалгаруулалтын хэлбэрээр зохион байгуулах зэрэг ажлыг хийсэн. Байгууллагын цахим хуудсанд Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, зурагт хуудас, сурталчилгааг байршуулан авлигын эсрэг олон нийтийн зүгээс мэдээлэх гомдол, мэдээллийг хүлээн авах ажлыг сурталчилсан байна.</p> <p>ТӨБЗГ нь АТГ-аас 2 жил тутамд зохион байгуулдаг Шударга байдлын үнэлгээнд хамрагдахаар судалгааны ажлын гүйцэтгэгчээр АТГ-аас сонгосон “Эс Ай Си Эй” ХХК-ийн судалгааны багтай хамтран ажиллаж, судалгааны ажилд дэмжлэг үзүүлэн, зохион байгуулалтаар хангаж ажиллав.</p> <p>Монголын дата клуб, Авлигатай тэмцэх газар, Нээлттэй нийгэм форум болон олон улсын “Opening Extractives” хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлсэн “Төрийн өмчит уул уурхайн компаниудын нийтэд ил тод мэдээллийг үр дүнтэй ашиглах замаар хяналт тавих, олон нийтийг бодит мэдээллээр хангах” зорилго бүхий “ТӨК-ийн өгөгдөлд нэвтрэхүй” 6 сарын хугацаатай өгөгдлийн</p>
--	--	---	---	----------------------	--

						<p>шинжилгээний төслийг дэмжин хамтран ажилласан бөгөөд Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ “Төрийн өмчит компаниуд дахь төрийн удирдлага, хяналт (Шийдвэрийг хэн гаргадаг, аль түвшинд байдаг) сэдвээр илтгэл тавьж оролцсон.</p> <p>Авлигатай тэмцэх газар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас хамтран 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулсан “Уул уурхайн салбар дахь авлигын эрсдэл ба гүйцэтгэх удирдлагын ёс зүй, ажлын үр дүнг тооцох нь” сэдэвт хэлэлцүүлэгт Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн Удирдлага, төлөөллийн албаны дарга, мэргэжилтэн нар оролцсон бөгөөд “Төрийн өмчит үйлдвэрийн газар, компаниудын өмчлөл, засаглал, үр өгөөжийг сайжруулах тухай” асуудлаар илтгэл тавьж хэлэлцүүлсэн.</p> <p>Хэрэгжилт – 100 хувь.</p>
10	4.2. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах.	Тухай бүр	<p>Гэрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар холбогдох заалтыг тусгасан эсэх;</p> <p>Гэрээний бүртгэл, хяналтыг хэрэгжүүлсэн байх.</p>	<p>Гэрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар холбогдох заалтыг тусгасан байна;</p> <p>Гэрээний бүртгэл хийсэн байна.</p>	Батлагдсан төсвийн урсгал зардал	<p>Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас төрийн өмчийн хувьцааг 100 хувь эзэмших эрхийг хэрэгжүүлдэг төрийн өмчит компанийн гүйцэтгэх захирал, төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал нартай байгуулах гэрээтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг шинэчилсэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 184 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын дагуу байгуулсан гэрээнд авлигаас урьдчилан сэргийлэх асуудалтай холбоотой заалтыг тусгасан болно. Нийт 49 хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулсан байна.</p> <p>Хэрэгжилт – 100 хувь</p>
11	4.3. Авлигын эсрэг байгууллагын соёлыг төлөвшүүлэх, удирдлагын манлайлал	Жилдээ	Авлигын эсрэг зөв ойлголт, хандлагыг төлөвшүүлэх арга	Авч хэрэгжүүлсэн тодорхой арга хэмжээний тоо –	Батлагдсан төсвийн урсгал	<p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг гарган Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. Төлөвлөгөөнд тусгагдсан нийт 6 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх</p>

үзүүлэх, санаачилга өрнүүлэх.		хэмжээ авсан байдал;	3<	зардал	<p>13 арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнасан бөгөөд АТГ-аас өгсөн чиглэлийн дагуу тайланг холбогдох нотлох баримт, хүснэгт, фото зураг зэргийн хамт Авлигатай тэмцэх газрын Авлигын эсрэг сүлжээний http://khutulbur.iaac.mn цахим систем дэх “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан”-ийн санд 2022.01.21-ний өдөр оруулан хуулийн хугацаанд баталгаажуулсан. Байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж хувь, үнэлгээ – 97.8 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” үнэлгээний дүнтэй байна.</p> <p>Авлигын эсрэг үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж ажилласан.</p> <p>Ерөнхий сайдын 2021 оны 120 дугаар захирамжаар байгуулагдсан “Авлигын индексийг бууруулах зорилго бүхий Ажлын хэсэг”-ийн авч хэрэгжүүлэх эрчимжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөөний 4 бүлгийн хүрээнд тусгагдсан холбогдох 10 арга хэмжээний биелэлтийг гаргаж, Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлд хүргүүлсэн. Хэрэгжилтийг 97.0 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан.</p> <p>“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан 7 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 31 арга хэмжээний 2021 оны хэрэгжилтийн тайланг холбогдох нотлох баримт, хүснэгт, фото зураг зэргийн хамтаар Авлигын эсрэг сүлжээ http://khutulbur.iaac.mn цахим системийн “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан”-ийн санд оруулан баталгаажуулсан. Хэрэгжилтийн дундаж хувь – 94.7 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” үнэлгээтэй байна.</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас өөрийн байгууллагын албан тушаал болон төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг 100 хувь хариуцан хэрэгжүүлдэг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 49 хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилохоор нэр дэвшүүлэх тухай бүрд Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг цахим хэлбэрээр гаргуулан бүртгэх, Авлигатай тэмцэх газарт</p>
-------------------------------	--	----------------------	----	--------	---

						<p>хүргүүлэн хянуулах ажлыг хэвшүүлсэн. 2022 онд дээр дурдсан албан тушаалын төрлүүдэд нэр дэвшсэн нийт 86+ нэр дэвшигчийн хувийн ашиг сонирхлын байдлыг хянуулсны үндсэн дээр томилох шийдвэр гаргасан байна.</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2022 онд төрийн өмчит 56 хуулийн этгээдийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, нэмэлт өөрчлөлтүүдийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем https://www.tender.gov.mn -д оруулах үйл явцад хяналт тавьж, цахим хэлбэрээр хянан баталгаажуулсан. Тэдгээрийн нийт батлагдсан төсөвт тусгагдсан 6 их наяд 98 тэрбум 157 сая төгрөг, тухайн онд санхүүжих 3 их наяд 710 тэрбум, 124 сая төгрөгийн үнийн дүн бүхий нийт 4,376 тендерийг зохион байгуулах төлөвлөгөөг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем https://www.tender.gov.mn -ээр хянан баталсан байна.</p> <p>Хэрэгжилт – 70 хувь.</p>
--	--	--	--	--	--	---

Зорилт 5. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах

12	5.1. Цахим хэлбэрт шилжүүлсэн үйлчилгээний талаар (И-Монголиад холбосон, автоматжуулсан үйлчилгээг оруулна) мэдээлэл.	4 дүгээр улиралд	<p>Үйлчилгээ байж болох боломжийг судалсан байх;</p> <p>Цахим хэлбэрт шилжүүлсэн үйлчилгээ, тоогоор.</p>	<p>Үйлчилгээ байж болох боломжийг судалсан байна;</p> <p>Цахим хэлбэрт шилжүүлсэн үйлчилгээ – 1<.</p>	Батлагдсан төсвийн урсгал зардал	<p>Тус байгууллагад И-Монгол системд холбох иргэдэд үзүүлэх үйлчилгээ байхгүй болно.</p> <p>Хүлээгдэж байгаа – ХБ.</p>
13	5.2. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд төрийн үйлчилгээний зохион байгуулалтыг өөрчилсөн, стандартыг шинэчилсэн талаар мэдээлэл.	3-4 дүгээр улиралд	<p>Зайлшгүй шаардлага бий эсэхийг судлах;</p> <p>Зохион байгуулалтын өөрчлөлт хийсэн эсэх;</p> <p>Стандартыг</p>	<p>Судалгаа хийж, шийдвэр гаргасан байна;</p> <p>Зохион байгуулалтын өөрчлөлт, стандартын шинэчлэл хийсэн</p>	Батлагдсан төсвийн урсгал зардал	<p>Одоогоор ийм өөрчлөлт, стандарт байхгүй болно.</p> <p>Хүлээгдэж байгаа – ХБ.</p>

			шинэчилсэн эсэх.	үйлчилгээ – 1<.		
14	5.3. Хүнд суртал, чирэгдлийг бууруулах, шат дамжлагыг цөөрүүлэх зорилгоор өөрчлөлт оруулсан дүрэм, журмын талаар мэдээлэл.	2-3 дугаар улиралд	Судалгаа хийх; Дүрэм, журмыг өөрчилсөн эсэх.	Судалгаа хийсний үндсэн дээр журам, журам өөрчлөх шаардлага байгаа эсэхэд шийдвэр гаргах; Өөрчлөлт оруулсан дүрэм, журам – 1<.	Батлагдсан төсвийн урсгал зардал	Хүнд суртал, чирэгдлийг бууруулах, шат дамжлагыг цөөрүүлэх шаардлагатай дүрэм, журам байхгүй. Хүлээгдэж байгаа – ХБ.
15	5.4. Авлигын эрсдэлийн үнэлгээ, үйл ажиллагаанд мониторинг, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулсан эсэх талаар мэдээлэл.	4 дүгээр улиралд	Үнэлгээ хийхэд шаардлагатай судалгаа хийсэн байх; Үнэлгээ, хувиар.	Судалгаа хийсэн байна; Үнэлгээ – 70< хувь.	Батлагдсан төсвийн урсгал зардал	Байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгчдээс үнэлгээ авах судалгааны ажлыг байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. Уг төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс 2023 оны 1 дүгээр сарын 16-ны хооронд зохион байгуулахаар агентлагийн даргын удирдамж гарган судалгааны ажлыг зохион байгуулж байна. Уг судалгаагаар эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр цаашид авах арга хэмжээг тодорхойлохоор төлөвлөсөн. Судалгааны дүн, дүгнэлт батлагдсан удирдамжийн дагуу 2023 оны 1 дүгээр сард танилцуулагдана. Хэрэглэгчийн үнэлгээний удирдамжийг файлаар хавсаргав. Хэрэгжилт – 70 хувь.

Зорилт 6. Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах

16	6.1. Төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлагад нийцүүлэн албан ёсны цахим хуудсыг хөгжүүлж, байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг олон нийтэд	Жилдээ, тухай бүр	Хууль тогтоомжийн дагуу нээлттэй байдлыг хангах арга хэмжээ авсан байх; Нээлттэй байдлын	Вэб сайтад тавигдах шаардлагыг хангах арга хэмжээ авсан байна; Вэб хуудасны хөгжүүлэлтийг	Батлагдсан төсвийн урсгал зардал	Төрийн байгууллагын вэб хуудсанд тавих шаардлагад нийцүүлэн байгууллагын албан ёсны цахим хуудсыг хөгжүүлж, байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг олон нийтэд цаг тухайд нь хүргэж байна. Байгууллагын цахим хуудсыг 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, түүнтэй холбоотой гарсан журмын дагуу шинэчлэн хөгжүүлэлт хийж, мэдээлэл, агуулгыг шинэчилсэн.
----	---	-------------------	---	--	----------------------------------	---

	цаг тухайд нь хүргэх.		хүртээмжийг нэмэгдүүлсэн байх.	шаардлага, стандартын дагуу хийсэн байна.		Хэрэгжилт – 100 хувь.
17	6.2. Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4, Авлигын эсрэг хуулийн 6.1.4, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дахь заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах.	Жилдээ, тухай бүр	Хуулийн хугацаанд мэдээ, мэдээллийг цахим хуудсанд байршуулсан байх; Хуулийн хэрэгжилт, хувиар.	Хуулийн хэрэгжилт – 90< хувь.	Батлагдсан төсвийн урсгал зардал	<p>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, нээлттэй мэдээлэх мэдээллийг хуулийн хугацаанд Шилэн дансны цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулан мэдээлж байна.</p> <p>Байгууллагын санхүүгийн гүйцэтгэлд сар бүр төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ болон төсвийн хэлбэлзлийн тайлантай тулган дотоод хяналтыг хийв. 2022 оны 11 дүгээр сарын байдлаар https://shilendans.gov.mn/org/7600 шилэн дансны цахим системд төсөв, гүйцэтгэлийн 6 төрлийн мэдээлэл 42, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 5 төрлийн мэдээлэл 38, бусад 6 төрлийн мэдээлэл 61, нийт 141 мэдээллийг байршуулсан байна. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг бүрэн мэдээлсэн байдал, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-д заасны дагуу мэдээллээ бүрэн илгээсэн байдлыг хянахад 2022 онд 1 мэдээллийг хугацаа хоцроосноос хэрэгжилт 99.35 хувьтай байна.</p> <p>Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем https://www.tender.gov.mn -д хууль, журмын дагуу худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл, тухайлбал, 2022 оны худалдан авах ажиллагааны батлагдсан төлөвлөгөө, зарлагдсан тендер, тендерийн үр дүнгийн мэдээллийг тухай бүр байршуулан ил тод, нээлттэй мэдээлсэн.</p> <p>2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, түүнтэй холбоотой гарсан журмын дагуу байгууллагын цахим хуудсыг шинэчлэн хөгжүүлж, зарим шинэчлэлийг хийсэн.</p> <p>Хэрэгжилт – 100 хувь.</p>

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг, Авлигатай тэмцэх газраас өгсөн чиглэл, зааврын дагуу “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын авлигын эсрэг үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөө”-г нийт 6 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх нийт 17 арга хэмжээг тусган баталж, хэрэгжилтийг ханган ажилласан.

Байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн дүн, жилийн эцсийн байдлаар:

Төлөвлөсөн нийт арга хэмжээ – 17; Үүнээс:

- “Үр дүнтэй” буюу 100 хувь хэрэгжсэн арга хэмжээ – 12;
- “Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70 хувьтай хэрэгжих шатанд байгаа арга хэмжээ – 2;
- “Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30 хувийн хэрэгжилт бүхий арга хэмжээ – 0;
- “Үр дүнгүй” буюу 0 хувь, хэрэгжээгүй, тасарсан – 0;
- “Үнэлэх боломжгүй” буюу өөрсдөөс хамаарахгүй болон хугацаа болоогүй байгаа арга хэмжээ – 3;

Хэрэгжилтийн дундаж хувь, үнэлгээ – 95.7 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” үнэлгээтэй байна.

Танилцсан:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Хянасан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ГАНБОЛД

Боловсруулсан:


ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Х.ЭНХЧИМЭГ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлангийн 1 дүгээр хавсралт

НЭГ. "АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ИРГЭДЭД СУРТАЛЧЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

Хавсралт №1.1.

№	Хэрэгжүүлсэн байдал	
Арга хэмжээ №1.1.	АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (facebook, twitter, youtube), лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэх	
Албан ёсны цахим хуудас	Вэб хаяг	https://pcsp.gov.mn
	Контентийн тоо	Нийтэлсэн - 14
	Давтамжийн тоо	Нийт хандалтын тоо -
Нийгмийн сүлжээ (facebook, twitter, youtube)	Сүлжээний нэр	Нийт – 2. сүлжээ: https://www.facebook.com/pcsp.gov.mn , youtube
	Контентийн тоо	Реклам – 3, АТГ-ын нийгмийн сүлжээн дэх хаягуудыг дагасан.
	Давтамжийн тоо	Нийт өдрийн тоо -
	Зарцуулсан хөрөнгө	-
	Санамж:	Байгуулсан гэрээ, зураг, бичлэг зэрэг нотлох баримтуудыг заавал файлаар хавсаргана.
	 <p>Зураг № 1. ТӨБЗГ-ын фэйсбук пэйж хуудас</p>	
Сурталчилгааны самбар	Сувгуудын нэр	Нийт – 4, Самбарын байршил: ТӨБЗГ-ын байр
	Контентийн тоо	Нийт контентийн тоо – 4
	Давтамжийн тоо	Самбар байршуулсан нийт өдрийн тоо – жилийн турш
	Зарцуулсан хөрөнгө	-
	Санамж:	Зураг нотлох баримтыг хавсаргав.
Бусад	Шалгуур үзүүлэлт	<ol style="list-style-type: none"> Бэлэн ном, товхимлын тавиур – 2 ш. Тавиурыг байнга буюу жилийн турш ажиллуулж, мэдээлэл түгээсэн. Стэнд 1 ш. Стэндийг 2021 оны ХАСХОМ-ийг шинэчлэн гаргах үеэр 2022.01.01-2022.02.15-ны өдрүүдэд мэдүүлэг гаргагчдад зориулан хуулийн заалт сурталчилсан.

№	Хэрэгжүүлсэн байдал			
Арга хэмжээ №1.2.	АТГ-аас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах			
АТГ-аас зохион байгуулсан аян, арга хэмжээ №1.	Салбар, орон нутгийн хэмжээнд аян зохион байгуулсан эсэх	Байгууллагын хэмжээнд		
	Зохион байгуулсан аяны тухай	Аяны нэр: "Зөв зөвд шударга зөв" аян Уриа: Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байя! Зорилго: Албан хаагч, олон нийтийн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх.		
	Тус аяны хүрээнд зохион байгуулсан арга хэмжээний нэр, төрөл	Хамрагдсан хүний тоо, авсан хандалтын тоо	Зарцуулсан хөрөнгө	
	Арга хэмжээ №1.1. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг сурталчлах	40	-	
	Арга хэмжээ №1.2. Урьдчилан сэргийлэх арга хэмжээг танин мэдүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлийн хор холбогдлыг сурталчлах	40	-	
	НИЙТ		80 /давхардсан тоогоор/	-
	Гарсан үр дүн	Үр дүн №1.1. Мэдээллийн хүртээмж сайжирсан. Үр дүн №1.2. Авлига, ашиг сонирхлын зөрчил бүртгэгдээгүй. Үр дүн №1.3. Албан хаагчид зөрчил, доголдол гаргахгүй байх ойлголт авсан, хариуцлага өндөржсөн.		
Санамж:	Зургаар нотолж харуулан хавсаргав.			

№	Хэрэгжүүлсэн байдал						
Арга хэмжээ №1.3.	Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбар ажиллуулах						
Мэдээллийн самбарыг шинэчилсэн мэдээллийн тоо, зарцуулсан хөрөнгийг доорх хүснэгтийн нүдэнд бөглөнө үү.							
Сар	Булан №1.	Булан №2.	Булан №3.	Булан №4.	Булан №5.	Нийт	Зарцуулсан хөрөнгө
2022 оны 1-р сар	...						
2022 оны 2-р сар							
...							
НИЙТ: Уг самбарыг ТӨБЗГ-ын нэр дээр АТГ-аас өгөөгүй болно.							
Санамж:	Мэдээллийн самбарт сар бүрийн байршуулсан мэдээллүүдийг нэгтгэж, нэг pdf файл болгоно. 12 ширхэг pdf файл, сар бүр авсан 12 зургийг заавал файлаар хавсаргана.						

ХОЁР. "АВЛИГЫН ЭСРЭГ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ, АЛБАН ХААГЧДЫГ СУРГАЛТАД ХАМРУУЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

№	Хэрэгжүүлсэн байдал				
Арга хэмжээ №2.1.	Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгуулахаар АТГ-т хүргүүлж, албан хаагчдаа холбогдох сургалтад хамруулсан байх				
Үзүүлэлт	ТӨБЗГ	Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын ажилтнууд	Орон нутгийн нэгжүүдийн ажилтнууд	Иргэд, бусад	Нийт
Сургалт, арга хэмжээний тоо	6		-	-	6

Хамрагдсан хүний тоо (давхардсан тоогоор)	170				170
Сургалтын сэдвийн тоо	10<				10<
Хамтран зохион байгуулсан байгууллагын тоо	2				2
Зарцуулсан хөрөнгө, мян. төгрөг	220.0	220.0
Санамж:	Сургалтын хөтөлбөрүүдийг хавсаргав.				

Хавсралт №2.2.а.

№	Хэрэгжүүлсэн байдал			
Арга хэмжээ №2.2.	Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан байдал:			
Үзүүлэлт	Сургалт, арга хэмжээний тоо	Хамрагдсан хүний тоо (давхардсан тоогоор)	Зарцуулсан хөрөнгө	
Сургалт / Авлигын эсрэг /	2	52	220.0	
Мэдээлэл, сурталчилгааны арга хэмжээ / Авлигын эсрэг хууль тогтоомж сурталчлах, соён гэгээрүүлэх чиглэлээр /	5 (мэдээллийн самбар, дотоод сүлжээ, утсаар, биечлэн, бичгээр хүргэсэн мэдээлэл, сурталчилгааг тооцов)	262	-	
Хэлэлцүүлэг зохион байгуулсан / Авлигаас урьдчилан сэргийлэх асуудлаар /	2 АТГ-ын хэлэлцүүлэгт)	3	-	
Хурал, зөвлөгөөн зохион байгуулсан / Авлигаас урьдчилан сэргийлэх асуудлаар /	-	-	-	
Сонсгол зохион байгуулсан / Авлигаас урьдчилан сэргийлэх асуудлаар /	1	-	-	
Бусад хэлбэрээр хууль тогтоомж, сурталчилгаа үйл ажиллагаа зохион байгуулсан	12<	119	-	
Санамж:	Сургалтын хөтөлбөрийг хавсаргав.			

Хавсралт №2.2.б.

№	Хэрэгжүүлсэн байдал			
Арга хэмжээ №2.2.	Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг сургагч багшаар дамжуулан зохион байгуулсан байдал:			
Сургагч багшаар бэлтгэгдсэн хүний тоо	1			
Үзүүлэлт	Сургалт / арга хэмжээний сэдвийн тоо	Хамрагдсан хүний тоо (давхардсан тоо)	Зарцуулсан хөрөнгө, мян.төг.	
Сургагч багш нарын зохион байгуулсан сургалт, сурталчилгааны арга хэмжээ №1.	1	31 ТӨБЗГ-ын албан хаагчид	-	
Сургагч багш нарын зохион байгуулсан сургалт, сурталчилгааны арга хэмжээ №2.	1	42 Салбар ЭБАТ	220.0	
Санамж:	Сургалтын хөтөлбөрийг хавсаргав.			

ГУРАВ. "АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРААС ХҮРГҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

Хавсралт №3.1.

№	Хэрэгжүүлсэн байдал										
Арга хэмжээ №3.1.	Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх										
Зөвлөмжийн нэр, дугаар	Тайлагнасан байдал			Арга хэмжээний тоо			Хэрэгжилт, %				Дундаж хувь
	Хариу ирүүлсэн	Хугацаанд нь хариу ирүүлсэн	Хариу ирүүлээгүй	Нийт	Давтагдах шинжтэй	Нэг удаагийн шинжтэй	100	70	30	0	
Зөвлөмж №1. Уул уурхайн салбарын төрийн өмчит үйлдвэрийн газруудын гүйцэтгэх удирдлагын ажлын үр дүн, урамшууллын эрх зүйн орчин, дүрэм журам, аргачлалд өөрчлөлт оруулах АТГ: 2022.12.05, №01/16426	үгүй	-	Хариу хүргүүлэх хугацаа болоогүй байгаа.	3	3	-	Хугацаа болоогүй, хүлээгдэж байгаа.

Хавсралт №3.2.

№	Хэрэгжүүлсэн байдал								
Арга хэмжээ №3.2.	Мөрдөгчийн мэдэгдэлд тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх								
Мэдэгдлийн нэр, дугаар	Тайлагнасан байдал			Арга хэмжээний тоо	Хэрэгжилт				Дундаж хувь
	Хариу ирүүлсэн	Хугацаанд нь хариу ирүүлсэн	Хариу ирүүлээгүй		100%	70%	30%	0%	
Мэдэгдэл №1. Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулах, 2021.12.22, № 01 (АТГ-ын албан бичиг: 2021.12.23, № 06/13971)	ТӨБЗГ, 2022.01.24, А-1/156	тийм		6	6				100
Мэдэгдэл №2. Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулах, 2022.03.22, № 32 (АТГ-ын албан бичиг: 2022.03.22, № 06/4012)	ТӨБЗГ, 2022.04.21, А-1/710	тийм		7	7				100
Мэдэгдэл №3. Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулах,	ТӨБЗГ, 2022.05.03, А-1/777	тийм		5	5				100

2022.04.04, № 45 (АТГ-ын албан бичиг: 2022.04.04, № 06/4558)									
Мэдэгдэл №4. Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулах, 2022.08.29, № 96 (АТГ-ын албан бичиг: 2022.08.30, № 06/10962)	ТӨБЗГ, 2022.01.20, А-1/170	тийм		1	1				100

Хавсралт №3.3.

№	Хэрэгжүүлсэн байдал								
Арга хэмжээ №3.3.	Зөрчил арилгуулах албан бичигт тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх								
Мэдэгдлийн нэр, дугаар	Тайлагнасан байдал			Арга хэмжээний тоо	Хэрэгжилт				Дундаж хувь
	Хариу ирүүлсэн	Хугацаанд нь хариу ирүүлсэн	Хариу ирүүлээгүй		100%	70%	30%	0%	
Мэдэгдэл №1. Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулах, 2021.12.22, № 01 (АТГ-ын албан бичиг: 2021.12.23, № 06/13971)	ТӨБЗГ, 2022.01.24, А-1/156	тийм		6	6				100
Мэдэгдэл №2. Хариуцлага тооцуулах тухай, АТГ-ын албан бичиг: 2022.01.06, № 05/289	ТӨБЗГ, 2022.01.24, А-1/156	тийм		2	2				100

ДӨРӨВ. "БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХҮСЭЛ ЭРМЭЛЗЭЛ,
САНААЧИЛГА ӨРНҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

Хавсралт №4.1.

№	Хэрэгжүүлсэн байдал				
Арга хэмжээ №4.1.	Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдээс гаргасан санал, санаачилгыг дэмжин туслах				
Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдээс гаргасан санал, санаачилга (байгууллага, нэр, саналын товч агуулга)		Шийдвэрийн товч агуулга:	Хамтран ажилласан	Татгалзсан	Судалж байгаа
Санаачилга №4.1.1. Төрийн байгууллагын "Шударга байдлын үнэлгээ"-ний асуумж, судалгааг авахаар ажилласан судалгааны "Эс Ай Си Эй" ХХК байгууллагатай хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлсэн.		Судалгаанд хамрагдах зохион байгуулалтыг хангаж ажилласан	Тийм		

<p>Санаачилга №4.1.2. “ТӨК-ийн өгөгдөлд нэвтрэхүй” өгөгдлийн шинжилгээ хийхэд Монголын дата клуб, Авлигатай тэмцэх газар, Нээлттэй нийгэм форум байгууллагын ажилд дэмжлэг үзүүлсэн.</p>	<p>Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ “Төрийн өмчит компаниуд дахь төрийн удирдлага, хяналт (Шийдвэрийг хэн гаргадаг, аль түвшинд байдаг) сэдвээр илтгэл тавьсан.</p>	Тийм		
<p>Санаачилга №4.1.3. “Уул уурхайн салбар дахь авлигын эрсдэл ба гүйцэтгэх удирдлагын ёс зүй, ажлын үр дүнг тооцох нь” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулахад АТГ-т дэмжлэг үзүүлсэн.</p>	<p>“Төрийн өмчит үйлдвэрийн газар, компаниудын өмчлөл, засаглал, үр өгөөжийг сайжруулах тухай” асуудлаар илтгэл тавьж оролцсон.</p>	Тийм		АТГ-аас гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэхээр судалж байна.
НИЙТ		3	-	1
Гарсан үр дүн	<p>Үр дүн №4.1.1. “Шударга байдлын үнэлгээ”-нд хамрагдсан.</p> <p>Үр дүн №4.1.2. Төрийн өмчит уул уурхайн компаниудын нийтэд ил тод мэдээллийг үр дүнтэй ашиглах замаар хяналт тавих, олон нийтийг бодит мэдээллээр хангах боломжийг бий болгоход анхаарсан.</p> <p>Үр дүн №4.1.3. Уг асуудлаар АТГ-аас зөвлөмж гаргаж, ТӨБЗГ-т ирүүлсэн. Зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг 2023 онд зохион байгуулахаар төлөвлөж байгаа.</p>			

Хавсралт №4.2.

№	Хэрэгжүүлсэн байдал				
Арга хэмжээ №4.2.	Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах				
Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулсан аливаа гэрээ, хэлэлцээрийн жагсаалт	Гэрээ байгуулсан байгууллагын өмчийн хэлбэр	Гэрээ байгуулсан огноо	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай заалт / зохицуулалт тусгасан эсэх		
			Тийм / Үгүй	Дээрх агуулгатай заалтын тоо	Заалт / зохицуулалтын утга, агуулга
<p>Гэрээ №4.2.1. “Төрийн өмчит хуулийн этгээдийн онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”</p>	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани (Төлөөлөн удирдах зөвлөлд чиглэл өгөх замаар)-ийн гүйцэтгэх захирал, Төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал	2022 оны 5-6 сард	Тийм	1	Компанийн тухай хуулийн дагуу Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд чиглэл өгөх замаар. ТӨҮГ-ын захиралтай ТӨБЗГ-аас гэрээг хийсэн.
НИЙТ: ТӨХЭ - 49				1	

Хавсралт №4.3.

№	Хэрэгжүүлсэн байдал			
